



# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2022/160/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)

Аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2-10
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4-5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7-8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8-9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13-14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14-15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16



ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БЯМБАЖАВ ТАНАА

### **Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			<i>Төгрөгөөр</i>	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>73,009,002.80</b>	<b>119,851,450.80</b>	
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	15,659,283.00	19,134,001.00	
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	15,659,283.00	19,134,001.00	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>57,349,719.80</b>	<b>100,717,449.80</b>	
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>2,864,352.00</b>	<b>2,864,352.00</b>	
35130	Эм боох материал	2,864,352.00	2,864,352.00	
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	2,000,000.00	2,000,000.00	
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>51,105,367.80</b>	<b>94,473,097.80</b>	
35410	Бичиг хэргийн материал	6,442,645.00	7,292,275.00	
35420	Аж ахуйн материал	5,856,570.00	8,315,770.00	
35430	Сэлбэг хэрэгсэл	215,000.00	4,009,500.00	
35470	Бусад хангамжийн материал	38,591,152.80	74,855,552.80	
35600	Мал амьтад	1,380,000.00	1,380,000.00	
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,174,698,720.41</b>	<b>2,169,023,110.68</b>	
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,174,698,720.41</b>	<b>2,169,023,110.68</b>	
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,159,170,720.41</b>	<b>2,152,770,110.68</b>	
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,855,435,347.00	1,852,047,797.00	
39202	Хуримтлагдсан элэгдэл	-198,135,856.60	-285,292,535.91	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	176,532,396.00	188,332,396.00	
39204	Хуримтлагдсан элэгдэл	-77,872,844.00	-58,721,451.44	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	129,087,308.00	122,222,185.00	
39206	Хуримтлагдсан элэгдэл	-84,008,848.62	-33,188,936.06	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,673,536.00	41,118,096.00	
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,796,164.30	-15,100,710.36	
39214	Бусад үндсэн хөрөнгө	355,253,500.00	363,998,500.00	
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,997,653.07	-22,645,229.55	
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>15,528,000.00</b>	<b>16,253,000.00</b>	
39301	Програм хангамж	2,705,000.00	1,985,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,020,000.00	-575,000.00	
39303	Бусад биет бус хөрөнгө	14,843,000.00	14,843,000.00	
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,247,707,723.21</b>	<b>2,288,874,561.48</b>	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,247,707,723.21</b>	<b>2,288,874,561.48</b>	
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,247,707,723.21</b>	<b>2,288,874,561.48</b>	
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	492,113,245.39	492,113,245.39	
51101	Өмч: - төрийн	492,113,245.39	492,113,245.39	
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,517,665,042.21</b>	<b>1,559,404,467.09</b>	
51210	Өмнөх үеийн үр дүн	1,517,665,042.21	1,518,237,628.82	
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	41,166,838.27	
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	237,929,435.61	237,356,849.00	
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,247,707,723.21</b>	<b>2,288,874,561.48</b>	

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			<i>Төгрөгөөр</i>	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>415,204,936.00</b>	<b>756,594,481.00</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>48,691,153.00</b>	<b>191,544,300.00</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>48,691,153.00</b>	<b>191,544,300.00</b>	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,691,153.00	00.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	48,691,153.00		



120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	00.00	123,117,900.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	00.00	46,956,400.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	21,470,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>366,513,783.00</b>	<b>565,050,181.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>56,887,083.00</b>	<b>47,229,481.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,700,000.00	13,855,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,705,738.00	19,474,949.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,981,345.00	10,899,532.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>309,626,700.00</b>	<b>517,820,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	309,626,700.00	517,820,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>417,668,649.73</b>	<b>685,731,809.48</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>417,668,649.73</b>	<b>685,731,809.48</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>415,854,649.73</b>	<b>591,568,287.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>186,487,718.00</b>	<b>256,933,531.00</b>
210101	Үндсэн цалин	184,889,646.00	250,438,919.00
210102	Нэмэгдэл	00.00	6,494,612.00
210104	Урамшуулал	578,072.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,020,000.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>23,617,271.00</b>	<b>34,172,731.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	16,233,899.00	23,934,075.97
210202	Тэтгэмжийн даатгал	1,845,843.00	2,569,135.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,476,676.00	2,055,308.41
210204	Ажилгүйдлийн даатгал	369,168.00	510,381.92
210205	Эрүүл мэндийн даатгал	3,691,685.00	5,103,829.18
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>41,332,759.00</b>	<b>65,131,579.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,927,630.00	5,491,752.00
210302	Түлш, халаалт	37,405,129.00	59,639,827.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,669,536.00</b>	<b>31,516,155.00</b>
210401	Бичиг хэрэг	2,156,150.00	2,985,870.00
210402	Тээвэр, шатахуун	23,010,246.00	20,079,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,160,400.00	2,529,585.00
210404	Ном, хэвлэл	78,500.00	374,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	77,000.00	85,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,187,240.00	5,461,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>997,100.00</b>	<b>1,315,000.00</b>
210604	Урсгал засвар	997,100.00	1,315,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>374,000.00</b>	<b>1,600,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	374,000.00	1,600,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>23,743,664.00</b>	<b>21,587,593.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,064,090.00	18,541,819.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,000.00	70,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	241,074.00	182,974.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	42,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	280,500.00	450,000.00
210807	Газрын төлбөр	00.00	2,300,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>109,632,601.73</b>	<b>179,311,698.48</b>



210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,944,995.00	50,013,622.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	1,910,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	89,587,606.73	127,387,576.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,814,000.00</b>	<b>94,163,522.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,814,000.00</b>	<b>4,120,500.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,814,000.00	3,620,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>90,043,022.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	90,043,022.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-2,463,713.73</b>	<b>70,862,671.52</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,000,000.00</b>	<b>29,695,833.25</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	28,695,833.25
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	6,000,000.00	1,000,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-6,000,000.00</b>	<b>-29,695,833.25</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-8,463,713.73</b>	<b>41,166,838.27</b>



**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

---

*Төгрөгөөр*



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			<i>Төгрөгөөр</i>	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>536,903,083.00</b>	<b>565,050,181.00</b>	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>536,903,083.00</b>	<b>565,050,181.00</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	57,677,083.00	47,229,481.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,700,000.00	13,855,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00	3,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,705,738.00	19,474,949.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,771,345.00	10,899,532.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	479,226,000.00	517,820,700.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	479,226,000.00	517,820,700.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>498,403,083.00</b>	<b>559,230,281.00</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>498,403,083.00</b>	<b>559,230,281.00</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>475,866,404.00</b>	<b>465,066,759.00</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	257,336,350.00	259,246,401.00	
210101	Үндсэн цалин	255,633,278.00	228,994,301.00	
210102	Нэмэгдэл	00.00	30,252,100.00	
210104	Урамшуулал	683,072.00	00.00	
210105	Гэрээт ажлын хөлс	1,020,000.00	00.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,364,215.00	35,334,579.00	
210201	Тэтгэврийн даатгал	23,312,277.00	25,124,917.00	
210202	Тэтгэмжийн даатгал	2,510,864.00	2,562,786.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,009,752.00	2,049,150.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	502,112.00	508,394.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	5,029,210.00	5,089,332.00	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	67,148,214.00	65,131,579.00	
210301	Гэрэл, цахилгаан	6,963,231.00	5,491,752.00	
210302	Түлш, халаалт	59,934,983.00	59,639,827.00	
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	00.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	49,332,606.00	32,878,985.00	
210401	Бичиг хэрэг	2,587,700.00	3,835,500.00	
210402	Тээвэр, шатахуун	33,620,866.00	20,079,600.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,810,320.00	2,529,585.00	
210404	Ном, хэвлэл	300,000.00	374,600.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	85,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,713,720.00	5,974,700.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,000,000.00	00.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	00.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,028,925.00	4,257,000.00	
210602	Тавилга	1,500,000.00	00.00	
210604	Урсгал засвар	3,528,925.00	4,257,000.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,144,000.00	1,600,000.00	
210702	Дотоод албан томилолт	1,144,000.00	1,600,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	31,260,844.00	21,551,643.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,315,770.00	18,505,869.00	
210803	Даатгалын үйлчилгээ	70,000.00	70,000.00	



210804	Тээврийн хэрэгслийн татвар	241,074.00	182,974.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	42,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	290,500.00	450,000.00
210807	Газрын төлбөр	255,500.00	2,300,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,251,250.00</b>	<b>45,066,572.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,151,250.00	43,156,072.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	1,910,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>22,536,679.00</b>	<b>94,163,522.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,500,000.00</b>	<b>4,120,500.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	3,620,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>19,036,679.00</b>	<b>90,043,022.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,036,679.00	90,043,022.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>38,500,000.00</u></b>	<b><u>5,819,900.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>38,500,000.00</b>	<b>5,819,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>38,500,000.00</b>	<b>5,819,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>38,500,000.00</b>	<b>5,819,900.00</b>
223001	Бусад хөрөнгө	35,100,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,400,000.00	5,819,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-38,500,000.00</u></b>	<b><u>-5,819,900.00</u></b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	472,820,700.00	427,777,678.00	45,043,022.00	90.5
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	472,820,700.00	427,777,678.00	45,043,022.00	90.5
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	469,150,700.00	424,182,178.00	44,968,522.00	90.4
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	270,157,600.00	259,246,401.00	10,911,199.00	96.0
210101	Үндсэн цалин	228,945,000.00	228,994,301.00	(49,301.00)	100.0
210102	Нэмэгдэл	41,212,600.00	30,252,100.00	10,960,500.00	73.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,899,000.00	35,334,579.00	2,564,421.00	93.2
210201	Тэтгэврийн даатгал	27,340,200.00	25,124,917.00	2,215,283.00	91.9
210202	Тэтгэмжийн даатгал	2,639,700.00	2,562,786.00	76,914.00	97.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,111,700.00	2,049,150.00	62,550.00	97.0
210204	Ажилгүйдлийн даатгал	527,900.00	508,394.00	19,506.00	96.3
210205	Эрүүл мэндийн даатгал	5,279,500.00	5,089,332.00	190,168.00	96.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	67,500,000.00	65,131,579.00	2,368,421.00	96.5
210301	Гэрэл, цахилгаан	7,600,000.00	5,491,752.00	2,108,248.00	72.3
210302	Түлш, халаалт	59,900,000.00	59,639,827.00	260,173.00	99.6



<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32,700,000.00	30,617,985.00	2,082,015.00	93.6
210401	Бичиг хэрэг	3,500,000.00	3,770,500.00	(270,500.00)	107.7
210402	Тээвэр, шатахуун	20,000,000.00	19,949,600.00	50,400.00	99.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000,000.00	2,529,585.00	1,470,415.00	63.2
210404	Ном, хэвлэл	400,000.00	374,600.00	25,400.00	93.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	85,000.00	215,000.00	28.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,000.00	3,908,700.00	591,300.00	86.9
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	23,724,900.00	7,447,000.00	16,277,900.00	31.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,500,000.00	3,190,000.00	310,000.00	91.1
210602	Тавилга	2,000,000.00	00.00	2,000,000.00	-
210604	Урсгал засвар	18,224,900.00	4,257,000.00	13,967,900.00	23.4
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,600,000.00	1,600,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	1,600,000.00	1,600,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,069,200.00	10,006,594.00	3,062,606.00	76.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,249,200.00	6,960,820.00	2,288,380.00	75.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00	300,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	70,000.00	70,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	182,974.00	317,026.00	36.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	42,800.00	157,200.00	21.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	2,300,000.00	2,300,000.00	-	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	22500000.00	14798040.00	7,701,960.00	65.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,500,000.00	12,887,540.00	7,612,460.00	62.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,910,500.00	89,500.00	95.5
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3670000.00	3595500.00	74,500.00	98.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,670,000.00	3,595,500.00	74,500.00	98.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,170,000.00	3,095,500.00	74,500.00	97.6
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>45,000,000.00</b>	<b>00.00</b>	45,000,000.00	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	45,000,000.00	00.00	45,000,000.00	-
223001	Бусад хөрөнгө	45,000,000.00	00.00	45,000,000.00	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	517,820,700.00	427,777,678.00	90,043,022.00	82.6
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	517,820,700.00	427,777,678.00	90,043,022.00	82.6
132001	Орон нутгийн төсвөөс	517,820,700.00	427,777,678.00	90,043,022.00	82.6
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25.00	22.00	3.00	88.0



620001	Удирдах ажилтан	10.00	10.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	03.00	02.00	1.00	66.7
620004	Гэрээт ажилтан	02.00	00.00	2.00	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		<i>Төгрөгөөр</i>
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>47,229,481.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>47,229,481.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	46,704,481.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,261,000.00
210401	Бичиг хэрэг	65,000.00
210402	Тээвэр, шатахуун	130,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,066,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,174,949.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,174,949.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	30268532.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,268,532.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	525000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	525,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	525,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	47229481.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	47,229,481.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,855,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,474,949.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,899,532.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газартай холбоотой шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх, авлага барагдуулах, тээвэр шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 10 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газар нь төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагааг иргэдэд хүргэх, төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад тайлант онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.



### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 677.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Авлагын дансны эхний үлдэгдэл 15.7 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 19.1 сая төгрөг болж 3.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд авлага нэмэгдсэн шалтгаан нь буруутай шийдвэр гаргаж ажлаас халагдсан алан хаагчийн нөхөн төлбөрт өгсөн 3.4 сая төгрөгтэй холбоотойгоор нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 57.3 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 100.7 сая төгрөг болж 43.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материалын дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тус байгууллага нь тайлант онд 38.5 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж үнэ тогтоон орлого авсан, 84.6 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс шилжүүлэн авсан, 21.4 төгрөгийн үндсэн хөрөнгийг хандиваар авсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 2,174.7 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 2,169.0 сая төгрөг болж буурсан байна. Энэ нь 39.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устгасан, 67.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж үнэ тогтоосон зэргээс шалтгаалсан байна.

Мөнгөн хөрөнгийн тухайд нийт орлого өмнөх онд 536.9 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 565.1 сая төгрөг болж 28.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тус байгууллагын санхүүгийн тайлангийн тодруулгад тайлант онд үүссэн авлага, үндсэн хөрөнгө, бараа материал болон мөнгөн хөрөнгө, төсвийн гүйцэтгэлийн талаарх бүхий л мэдээллийг бүрэн тусгасан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны төсвийн төслийг 624.7 сая төгрөгөөр төлөвлөн боловсруулж төсвийн саналаа тус сумын төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэн нэгтгүүлсэн бөгөөд төсвийг анх 423.9 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 423.9 сая төгрөгийн төсөв баталсан бөгөөд тодотголоор 93.9 сая төгрөгийн төсвийг нэмж нийт 517.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төсөвт өөрчлөлт оруулан баталсан байна.



Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 517.8 сая төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний зардалд 424.2 сая төгрөгийг зарцуулж урсгал шилжүүлгийн зардалд 3.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн төсвийн хэмнэлт гарган ажиллаж орон нутгийн төсөвт 90.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн бөгөөд төсвийн гүйцэтгэл 90.5 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 10.9 сая төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газраас мал тооллогын зардалд 1.2 сая төгрөг, хамтарсан багийн зардалд 0.3 сая төгрөг, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 3.0 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 2.0 сая төгрөг, хандив тусламжаар 16.8 сая төгрөг, үлийн цагаан оготно устгалын зардалд 13.0 сая төгрөг нийт 47.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас Хангамж, бараа материалын зардал 2.3 сая төгрөгийг, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 14.2 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 30.3 сая төгрөгийг, урсгал шилжүүлгийн зардалд 0.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь тогтоогдож шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн орсон албан хаагчийн ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөрт байгууллагын төсвөөс нийт 13.3 сая төгрөгийг төлсөн байна. Уг төлбөрийг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаас авлага үүсгэн бүртгэсэн боловч авлагыг барагдуулаагүй байна.

Дээрх асуудлыг Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2.”Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албанд шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

### **Бусад асуудлын хэсэг**

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага:

- Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.
- Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.
- Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



### **3.8 Аудитын гол асуудал**

Шуудан холбооны зардлаас Засаг даргын Тамгын газрын ажилчдын гар утасны төлбөрийг нэг удаа урамшуулал хэлбэрээр төлсөн байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

Шатах тослох материалын зарцуулалтад хяналт тавьж жолоочийн тооцооны хуудсыг бичиж хэвшээгүй, илүү дутууг нь тооцож ажиллаагүй байна. Энэ нь НББ тухай хуулийн 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно... гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тус байгууллагын дансанд 19.1 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас буруутай шийдвэр гаргаж ажлаас халагдсан алан хаагчийн нөхөн төлбөртэй холбоотой 13.3 сая төгрөгийн авлага, хувь хүмүүсээс авах өвс тэжээлийн тооцооны үлдэгдлийн 5.9 сая төгрөгийн авлага байна. Уг авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд нь ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд нийт 843.6 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 86.7 сая төгрөгийн 3 мэдээл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан хэсэгт 6.0 сая төгрөгийн 4 мэдээл нийт 150.7 сая төгрөгийн 7 мэдээллийг мэдээлээгүй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээний хэрэгжилт баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 38.5 сая төгрөгийн 2 алдаа, 19.8 сая төгрөгийн 3 зөрчил илэрснээс аудитын хугацаанд 38.5 сая төгрөгийн 2 алдааг залруулж 19.8 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн.



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 150.7 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг өгсөн.

## **Залруулсан алдаа**

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 38.5 сая төгрөгийн залруулгыг хийсэн. Үүнд:

Шилжүүлэн авсан 9.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан гэж буруу бүртгэснийг залруулсан.

Үндсэн хөрөнгийг данснаас 28.7 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг данснаас хасаж шилжүүлэхдээ үнэ төлбөргүй гарсан зардлаар бүртгэснийг үндсэн хөрөнгө данснаас хассан гарзаар бүртгүүлж залруулсан.

### **4.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Авлагын данстай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Тус байгууллагын дансанд 19.1 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас буруутай шийдвэр гаргаж ажлаас халагдсан алан хаагчийн нөхөн төлбөртэй холбоотой 13.3 сая төгрөгийн авлага, хувь хүмүүсээс авах өвс тэжээлийн тооцооны үлдэгдлийн 5.9 сая төгрөгийн авлага байна. Уг авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж авлагыг барагдуулах.

#### **2. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **2.1. Илрүүлэлт:**

Шуудан холбооны зардлаас Засаг даргын Тамгын газрын ажилчдын гар утасны төлбөрийг нэг удаа урамшуулал хэлбэрээр төлсөн байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

##### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Төсвийг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, урамшуулал хэлбэрээр ажилчдын утасны төлбөрийг төлөхгүй байх.

#### **3. Дотоод хяналттай холбоотой асуудал**

##### **3.1. Илрүүлэлт:**

Шатах тослох материалын зарцуулалтад хяналт тавьж жолоочийн тооцооны хуудсыг бичиж хэвшээгүй, илүү дутууг нь тооцож ажиллаагүй байна. Энэ нь НББ тухай хуулийн 13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно... гэсэн заалттай нийцэхгүй байна.

##### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Түлш шатах тослох материалын зарцуулалтад хяналт тавьж жолоочийн тооцооны хуудсыг бодож, илүү дутууг нь тооцон баталгаажуулж байх.

#### **4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал**

##### **4.1. Илрүүлэлт:**

цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 86.7 сая төгрөгийн 3 мэдээл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл



шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан хэсэгт 6.0 сая төгрөгийн 4 мэдээл нийт 150.7 сая төгрөгийн 7 мэдээллийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дахь хэсэгтэй нийцэхгүй байна.

**4.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв бүрэн мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Д / Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	<b>Цэцэрлэг сумын ЗДТГ</b> <i>Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой</i>	5	58.3	2	38.5					3	19.8
2	<b>Цэцэрлэг сумын ЗДТГ</b> <i>Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой</i>	7	150.7							1	150.7
<b>Дүн</b>		12	209.0	2	38.5					4	170.5

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

Б.ДАВААНЯМ ОГНОО:



### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Төгрөгөөр
						Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	492,113,245.39	237,929,435.61	1,499,941,024.94	00.00	2,229,983,705.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>492,113,245.39</b>	<b>237,929,435.61</b>	<b>1,499,941,024.94</b>	<b>00.00</b>	2,229,983,705.94
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	28,932,492.61	00.00	28,932,492.61
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>492,113,245.39</b>	<b>237,929,435.61</b>	<b>1,517,665,042.21</b>	<b>00.00</b>	2,247,707,723.21
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>492,113,245.39</b>	<b>237,929,435.61</b>	<b>1,517,665,042.21</b>	<b>00.00</b>	2,247,707,723.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	572,586.61	00.00	572,586.61
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>492,113,245.39</b>	<b>237,929,435.61</b>	<b>1,518,237,628.82</b>	<b>00.00</b>	2,248,280,309.82
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-572,586.61	00.00	00.00	-572,586.61
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	41,166,838.27	00.00	41,166,838.27
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>492,113,245.39</b>	<b>237,356,849.00</b>	<b>1,559,404,467.09</b>	<b>00.00</b>	2,288,874,561.48